



## ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 07 өдөр

Дугаар А-02

Улаанбаатар хот

### Төлөвлөгөө батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэг, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журмын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний хөгжлийн газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөний биелэлтийг хангаж, хуульд заасан хугацаанд тайлагнахыг нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга /Н.Орхон/-д даалгасугай.

ДАРГА



Х.БАТЖАРГАЛ

Үндэсний хөгжлийн газрын даргын  
2021 оны 02 дугаар сарын 07  
ны өдрийн А-02 дугаартай  
тушаалын хавсралт



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР

# ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Улаанбаатар хот

## ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа I-IV улирал/	Хариуцах нэгж
1.Монгол Улсын 2021-2025 оны улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх	Төсвийн урсгал зардлаар	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөл боловсруулсан байх /Хувь/	Улсын Их хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан.	Төслийг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. /100 хувь/	I - II улирал	СШХ
2.Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төслүүдийг үнэлж, эрэмбэлэх аргачлал боловсруулах		Аргачлалын тоо /Тоо/	Засгийн газрын 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 348 дугаар тогтоолоор батлагдсан журам.	Аргачлал боловсруулагдсан байна. / 2 аргачлал/	I - II улирал	
3."Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журам"-ын шинэчилсэн найруулгыг боловсруулж, батлах		Журмын тоо /тоо/	Газрын даргын 2019.09.04-ний өдрийн А-158 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан.	Журмыг баталж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн байна. / 1 журам/	II-III улирал	БОНХБТХ
4. "Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр" боловсруулах	Улсын төсөв	Хөтөлбөр боловсруулсан байх /Хувь/	-	Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг боловсруулсан байна. /100 хувь/	I-IV улирал	БОНХБТХ
5.Хөгжлийн 6 зорилтот хөтөлбөрийн төслийг боловсруулахад шаардлагатай нөхцөл байдлын дүн шинжилгээг хийх		Судалгааны тоо /Тоо/	-	Зорилтот хөтөлбөр тус бүрд нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, судалгаа гарсан байна. /6 судалгаа/	I-IV улирал	ХБТХ

6.Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөл боловсруулах	Төсвийн урсгал зардлаар	Төлөвлөгөөний төслийг боловсруулсан байх /Хувь/	Улсын Их хурлын 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 54 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл.	Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөл боловсруулсан байна. <b>/100 хувь/</b>	I-III улирал	ХБТХ
7.Төсөл хөгжүүлэх сан байгуулах талаар гадаад орнуудын туршлагын судалгаа хийх	Улсын төсөв	Судалгааны тоо /Тоо/	-	Судалгаа хийгдсэн байна. <b>/1 судалгаа/</b>	I-IV улирал	СШХ
8.Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах	Улсын төсөв	Хуулийн төслийг боловсруулсан байх /Хувь/	Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгаа, тайлан, холбогдох хуулийн харьцуулсан судалгааны ажлуудыг хийсэн.	Хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. <b>/100 хувь/</b>		ХОБТХ
9.Хувийн хэвшлийн санхүүгийн санаачилгыг дэмжих тухай хуулийн төслийн олон улсын туршлагын талаарх харьцуулсан судалгааг хийх		Судалгааны тоо /Тоо/	-	Олон улсын шилдэг туршлагын талаар судалгаа хийсэн байна <b>/ 1 судалгаа/</b>		
10. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан холбогдох журмын төслүүдийг боловсруулах		Журмын тоо /Тоо/	Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгаа, тайлан, холбогдох хуулийн харьцуулсан судалгааны ажлуудыг хийсэн	Тогтворжуулах гэрчилгээ олгох журам, Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журам, Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмын төслийг тус тус боловсруулсан байна. <b>/3 журмын төсөл/</b>		
11.Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулж хөрөнгө оруулалт, бизнесийн эрх зүйн хууль тогтоомжийн албан бус орчуулгыг хийж, мэдээллийн санг бүрдүүлэх	Төсвийн урсгал зардлаар	Хууль тогтоомжийн жагсаалт гаргасан байх /Хувь/	-	Орчуулагдах хуулийн жагсаалтыг гаргасан байна. <b>/100 хувь/</b>	I-IV улирал	
12.Үндэсний хөгжлийн хүрээлэн-Засгийн газрын тинктанк байгуулах техник,	-	Техник эдийн засгийн урьдчилсан судалгааны тоо	Суурь судалгаа хийсэн.	Техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа хийсэн байна.	I – IV улирал	СШХ

эдийн засгийн урьдчилсан судалгаа хийх		/Хувь/		/100 хувь/		
13.Тэргүүлэх чиглэлийн төслүүдийг үнэлж эрэмбэлэн, холбогдох байгууллага руу хүргүүлсэн байх	Улсын төсөв	Судалгааны тоо /Тоо/	-	Үнэлгээ, эрэмбэлэлтийн үр дүнг холбогдох байгууллага руу хүргүүлсэн байна. <b>/1 судалгаа/</b>	I-II улирал	
14.Аялал жуулчлалын hub-sporke системийн зангилаа төвүүдэд орон нутгийн бизнес эрхлэгч, бүтээгдэхүүн борлуулалтыг дэмжсэн загвар төв байгуулах төслийн техник эдийн засгийн урьдчилсан судалгаа хийх	Улсын төсөв	Техник эдийн засгийн урьдчилсан судалгааны тоо /Тоо/	2020 онд 2 төслийн суурь судалгаа, 1 төслийн техник эдийн засгийн урьдчилсан судалгаа хийсэн.	Техник эдийн засгийн урьдчилсан судалгаа боловсруулагдсан байна. <b>/1 ТЭЗУС/</b>	I-IV улирал	СШХ
15.Нэн хэрэгцээтэй хүний нөөцийн эрэлт, хэрэгцээний судалгаа хийх	Төсвийн урсгал зардлаар	Судалгааны тоо /Тоо/	2020 оны түвшинд нэн хэрэгцээтэй хүний нөөцийн эрэлт, хэрэгцээний судалгаа гарсан	Томоохон төслүүдийн хүрээнд нэн хэрэгцээт хүний нөөцийн эрэлт хэрэгцээний судалгаа хийсэн байна. <b>/1 судалгаа/</b>	I-IV улирал	СШХ
16.Япон улстай дулааны аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүн, дайвар түүхий эд, гүн хөлдөөсөн хонь, ямааны мах экспортлох чиглэлээр импортлогч талын нөхцөл, шаардлагыг судлах			-	Судалгаа хийгдсэн байна. <b>/1 судалгаа/</b>	I-IV улирал	
17.Макро эдийн засгийн бодлого болон хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудлыг салбар хооронд уялдуулан зохион байгуулахад чиглэсэн судалгааг хийх	Төсвийн урсгал зардлаар	Судалгааны тоо /Тоо/	-	Судалгааг хийсэн байна. <b>/1 багц судалгаа/</b>	I-IV улирал	ХБТХ
18.Үндэсний хөтөлбөр, бусад бодлогын баримт бичгүүдтэй холбоотойгоор Үндэсний хөгжлийн газрын хариуцан гүйцэтгэх ажлын хүрээнд багц судалгаа хийх			-	Судалгааг хийсэн байна. <b>/1 багц судалгаа/</b>	I - IV улирал	

19.Ковид - 19 цар тахлын үед эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг дэмжих бодлогын судалгаа хийж, санал боловсруулах		Судалгааны тоо /Тоо/	Судалгаа хийгдэж эхэлсэн	Судалгааг хийсэн байна. /1 судалгаа/	I-II улирал	СШХ
20.Нийслэлийн нийтийн тээврийн салбарын суурь судалгааг шинэчлэх			Суурь судалгааг 2019 оны байдлаар хийсэн.	Судалгааг хийсэн байна. /1 судалгаа/	II – IV улирал	
21. Улсын 2022 оны төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгнө.	Төсвийн урсгал зардлаар	2022 улсын төсвийн төсөлд зөвшөөрөл өгсөн байх  /Удаа/	2021 он Улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар 2020 онд зөвшөөрөл өгсөн.	Улсын төсвийн төслийг Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд нийцсэн эсэхийг нягтлан шалгаж, жил бүр зөвшөөрөл өгсөн байна.  / 1 удаа/	I - IV улирал	ХБТХ
22.Тогтвортой хөгжлийн асуудлаар зохион байгуулагдах хурал, арга хэмжээнд оролцох		Хурал, уулзалтад оролцсон тоо /Тоо/	2020 онд 5 хурал, уулзалтад оролцсон.	Тогтвортой хөгжлийн асуудлаар 2020 онд зохион байгуулагдсан хурал, уулзалтад оролцож, тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг танилцуулна. / 10 хурал, уулзалт/	I-IV улирал	
23.Тогтвортой хөгжлийн зорилгын үндэсний зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийн төслийг боловсруулсан байх	Төсвийн урсгал зардлаар	Төслийн тоо /Тоо/	-	Тогтвортой хөгжлийн зорилгын үндэсний зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийн төслийг боловсруулсан байна. /1 төсөл/	I-IV улирал	ХБТХ
24.Тогтвортой хөгжлийн үндэсний хорооны үйл ажиллагаатай холбоотой журам, дүрмийн төсөл боловсруулсан байх		Төслийн тоо /Тоо/	-	Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийн хуралдааны дэгийн төсөл болон үйл ажиллагааны журмын төслийг тус тус боловсруулсан байна. / 2 төсөл/	I-IV улирал	
25.Тогтвортой хөгжлийн зорилго, хөгжлийн бодлогын	Төсвийн урсгал	Хэрэгжүүлсэн төслийн тоо	-	Нэгдсэн Үндэстний байгууллага болон олон	I-IV улирал	

чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран төсөл хэрэгжүүлэх	зардлаар	/Тоо/		улсын бусад байгууллагуудтай хамтран төсөл хэрэгжүүлсэн байна. <b>/2 төсөл/</b>		
26.Оюутолгой, Эрдэнэт зэрэг томоохон үйлдвэрийн захиалгат ажлыг үндэсний жижиг, дунд бизнес эрхлэгчид гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлнэ.	Төсвийн урсгал зардлаар	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргасан байх <b>/Хувь/</b>	-	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргасан байна. <b>/ 100 хувь/</b>	I-IV улирал	ХОБТХ
27.Дэлхийн банкны "Бизнес эрхлэхүй" тайланд Монгол Улсын эзлэх байр суурийг ахиулах	Төсвийн урсгал зардлаар	Ажлын хэсэг Байгуулах  <b>/Хувь/</b>	-	Дэлхийн банкны "Бизнес эрхлэхүй" тайланд Монгол Улсын эзлэх байр суурийг ахиулах тал дээр төрийн байгууллагуудтай хамтран ажиллах ажлын хэсэг байгуулж ажилласан байна. <b>/ 100 хувь/</b>	I-IV улирал	ХОБТХ
28.Монгол, Казахстаны Засгийн газрын хоорондын комиссын ээлжит VIII хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний 2 дугаар заалтад тусгагдсан ажлыг ЗТХЯамтай бүрэлдэхүүн нийлүүлэх болон бусад салбарын төслүүдийг хэрэгжүүлэх боломжийг хамтран судлах	Төсвийн урсгал зардлаар	Судалгаа хийгдсэн байх  <b>/Хувь/</b>	-	Казахстаны Хөгжлийн банкны санхүүжилтээр Монгол Улсын төмөр зам, түүний хөдлөх бүрэлдэхүүн нийлүүлэх болон бусад салбарын төслүүдийг хэрэгжүүлэх боломжийг судалсан байна. <b>/ 100 хувь/</b>	I-IV улирал	ХОБТХ
29.Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, гомдлыг шийдвэрлэх	Төсвийн урсгал зардлаар	Хөрөнгө оруулагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдол хүсэлтийг тухай бүр шийдвэрлэсэн байх <b>/Хувь/</b>	"Хөрөнгө оруулагчаас гаргасан гомдлыг цахим хэлбэрээр бүртгэх, шийдвэрлэлтэд хяналт тавих систем- SIRM"-ийг ашиглалтад оруулсан.	Хөрөнгө оруулалттай холбоотой гомдлыг маргаан болж шүүх, арбитраж очихоос өмнө урьдчилан сэргийлэх, гомдлыг барагдуулах хүрээнд олон улсын эрхзүйн зөвлөх, шинжээчдийн дүгнэлтэд үндэслэн Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, гомдлыг тухай бүр шийдвэрлэсэн байна. <b>/100 хувь/</b>	I-IV улирал	ХОБТХ
30.Гадаад, дотоодын бизнес эрхлэгч хөрөнгө оруулагчдад хамтрагч, түншээ олоход нь зориулсан бизнес форум, арга		Форум, арга хэмжээний тоо <b>/Тоо/</b>	2020 онд 2 арга хэмжээг зохион байгуулсан.	МУ-ын эдийн засаг, хөрөнгө оруулалтын орчны талаарх эерэг мэдээллийг хөрөнгө	I-IV улирал	

хэмжээг зохион байгуулах	Улсын төсөв			оруулагчдад хүргэж, хөрөнгө оруулалт шаардлагатай төслүүдийг сурталчилсан арга хэмжээг цахимаар охион байгуулсан байна. <b>/ 2 арга хэмжээ/</b>		
31.Дотоодын бизнес эрхлэгчдийг дэмжсэн төсөл чадавхижуулах Академи байгуулах		Академи байгуулах бэлтгэл ажлыг хангаж ажилласан байх  <i>/Хувь/</i>	-	Академи байгуулах бэлтгэл ажлын хүрээнд төсөл чадавхижуулах сургалт явуулж эхлэх, төсөл танилцуулсан байна. <b>/100 хувь/</b>	I-IV улирал	ХОДСХ
32.“Your Guide to Invest in Mongolia” хөрөнгө оруулалтын гарын авлага хөтөч номыг 2021 оны хувилбараар шинэчлэн гаргах	Төсвийн урсгал зардлаар	Хөтөчийн тоо <i>/Тоо/</i>	2020 онд Хөрөнгө оруулалтын гарын авлагыг шинэчилсэн.	“Your Guide to Invest in Mongolia” хөрөнгө оруулалтын гарын авлага хөтөч номыг 2021 оны хувилбараар шинэчлэн гаргасан байна. <b>/1 гарын авлага/</b>	I,II улирал	
33.Дотоодын хөрөнгө оруулалт шаардлагатай төслүүдийг эмхэтгэсэн эмхтгэл гаргах		Эмхтгэлийн Тоо  <i>/Тоо/</i>	2020 онд төслийг эмхтгэж, төслийн цахим ном болгон гаргаж, сурталчилсан.	Төслийн цахим ном болгон гаргаж, сурталчилсан. <b>/1 эмхтгэл/</b>	I,II улирал	
34.Хөрөнгө оруулагчдад зориулсан “invest in Mongolia Newsletter” цахим сэтгүүл гаргах, сурталчлах		Цахим сэтгүүл гарсан байх  <i>/Хувь/</i>	-	Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан “invest in Mongolia Newsletter” цахим сэтгүүлийг тогтмол гаргана. <b>/ 100 хувь/</b>	I-IV улирал	
35.Хөрөнгө оруулагчийн оршин суух зөвшөөрлийн хүсэлтийг цахимаар олгох.	Төсвийн урсгал зардлаар	Хүсэлтийг тухай бүр шийдвэрлэсэн байх <i>/Хувь/</i>	2021 онд ажлын 8 цагт “www.invest-assist.gov.mn” цахимаар олгож байна.	Монгол Улсад хөрөнгө оруулалт хийсэн эсэх, татварын тайлан гаргаж татвар, хураамж төлдөг эсэх, Монгол иргэдийг ажлын байраар ханган нийгмийн даатгалын тайлан өгч, шимтгэлээ төлдөг эсэхийг нягтлан цахимаар хөрөнгө	I-IV улирал	ХОДСХ

				оруулагчид оршин суух зөвшөөрлыг тухай бүр олгосон байна. <b>/ 100 хувь/</b>		
36.Байгууллагаас хөрөнгө оруулагчдад олгож буй төрийн цахим үйлчилгээг нэгтгэж E-Mongolia платформд нэгтгэх		Мэдээллийг E-Mongolia платформд нэгтгэсэн байх <b>/Хувь/</b>	-	Үндэсний хөгжлийн газраас хөрөнгө оруулагчдад олгож буй төрийн цахим үйлчилгээг E-Mongolia платформд нэгтгэсэн байна. <b>/ 100 хувь/</b>		
37.Монгол Улсын хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдээллийг нэгдсэн санд оруулж, бүртгэнэ. <a href="http://www.industry4.nda.gov.mn">www.industry4.nda.gov.mn</a>	Улсын төсөв	Үйлдвэрлэгчдийн мэдээллийг нэгтгэсэн тоо <b>/Тоо/</b>	3700 үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдээллийг бүртгэсэн.	Аж үйлдвэрийн салбарын цахим мэдээллийн системд үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдээллийг нэмж нэгтгэнэ. <b>/ 50 үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдээлэл/</b>	I – IV улирал	БОНХБТХ
38.Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулах	-	Боловсруулсан баримт бичгийн тоо <b>/Тоо/</b>	Суурь судалгаанууд хийгдсэн.	Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төслийг боловсруулсан байна. <b>/1 төсөл/</b>	I-IV улирал	БОНХБТХ
39.Орон нутгийн хөгжлийн индексийг сум, аймаг, бүс тус бүрээр нэгтгэх	-	Орон нутгийн хөгжлийн индекс 330 сумын мэдээллийг нэгтгэсэн байх <b>/Хувь/</b>	2019 оны мэдээллийг нэгтгэсэн.	Нийт 330 сумын мэдээллийг <a href="http://www.sector.gov.mn">www.sector.gov.mn</a> -д 2020 оны байдлаар нэгтгэсэн байна. <b>/100 хувь/</b>	I-IV улирал	
40.Тогтвортой хөгжил, түншлэлийн зөвлөлийг орон нутагт байгуулах	Буцалтгүй усламж	Зөвлөл байгуулсан аймгийн тоо <b>/Тоо/</b>	2020 онд 10 аймагт Тогтвортой хөгжил, түншлэлийн зөвлөлийг байгуулсан.	Аймгуудад тогтвортой хөгжил, түншлэлийн зөвлөлийг байгуулж бэхжүүлсэн байна <b>/2 аймаг/</b>	I-IV улирал	БОНХБТХ
41.Олон Улсын байгууллагатай хамтран төсөл хэрэгжүүлэх		Төслийн тоо <b>/Тоо/</b>	-	Нэгдсэн Үндэстний байгууллага болон Германы хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран төсөл хэрэгжүүлсэн байна. <b>/2 төсөл/</b>	I-IV улирал	

42.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"Алсын хараа-2050"-ийн хэрэгжилт		Явцын тайлан гарсан байх /Хувь/	-	Тайланг нэгтгэн боловсруулж дууссан байна.. /100 хувь/	III улирал	ХШУДАХ
43.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	Төсвийн урсгал зардлаар	Хяналт-шинжил-гээ, үнэлгээ-ний тайлан гарсан байна. /Хувь/	2020 оны эхний хагас жилийн тайланд ХШУ хийж ЗГХЭГ-т хүргүүлсэн. ХШУ-ний мэдээллийн санд хугацаанд нь тайлагнасан.	2020 оны жилийн эцсийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. /100 хувь/	I улирал	
44.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт		Хяналт-шинжил-гээ, үнэлгээ-ний тайлан гарсан байна. /Хувь/	2020 оны эхний хагас жилийн тайланд ХШУ хийж ЗГХЭГ-т хүргүүлсэн. ХШУ-ний мэдээллийн санд хугацаанд нь тайлагнасан.	2020 оны сүүлийн хагас жил болон 2021 оны эхний хагас жилийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. /100 хувь/	I, II улирал	
45.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	Төсвийн урсгал зардлаар	Хяналт-шинжил-гээ, үнэлгээ-ний тайлан гарсан байна. /Хувь/	2020 оны эхний хагас жилийн тайланд ХШУ хийж ЗГХЭГ-т хүргүүлсэн. ХШУ-ний мэдээллийн санд хугацаанд нь тайлагнасан.	2020 оны жилийн эцэс болон 2021 оны эхний хагас жилийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. /100 хувь/	I, II улирал	
46.Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт		Тайлан нэгтгэсэн байна. /Хувь/	Үндэсний хөтөлбөрийн 2019 оны явцын мэдээллийг 2020 оны 2 сарын 19-ны өдрийн 01/498 бичгээр ЗГХЭГ-д хүргүүлсэн.	2020 оны жилийн эцсийн байдлаар тайланг нэгтгэсэн байна. /100 хувь/	I улирал	
47.Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилт		Хяналт-шинжил-гээ, үнэлгээ-ний тайлан гарсан байна. /Хувь/	2019 оны тайланг 2020.02.11-ны өдрийн 01/411 албан тоотоор Сангийн яаманд хүргүүлсэн.	2020 оны жилийн эцсийн байдлаар тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. /100 хувь/	I улирал	
48.Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Төсвийн урсгал	Хяналт-шинжил-гээ, үнэлгээний тайлан гарсан байх /Хувь/	2020 оны тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ЗГХЭГ-т хүргүүлсэн.	2021 оны гүйцэтгэлийн тайлангийн эхний хагас жилд явцын хяналт-шинжилгээ, жилийн эцсээр хяналт-шинжилгээ,	II, IV улирал	

	зардлаар			үнэлгээ хийсэн байна. <b>/100 хувь/</b>		
49.Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх		Хяналт-шинжилгээ, үнэлгээ-ний тайлан гарсан байна. <b>/Хувь/</b>	2019 оны үйл ажиллагаанд хшү хийсэн. 2019 онд 80.4 хувь буюу 4.02 үнэлсэн.	2020 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлан гаргасан байна. <b>/100 хувь/</b>	I улирал	
50.Байгууллагын Шилэн дансны мэдээлэлд явцын хяналт хийх	Төсвийн урсгал зардлаар	Тайлан гарсан байх <b>/Хувь/</b>	Байгууллагын 2019 оны 10-12 сар болон жилийн эцсийн мэдээлэл, 2020 оны 1-4 сар болон I улирлын мэдээлэл тайлагнасан байдалд явцын хяналт хийсэн.	Байгууллагын шилэн дансны 2020-2021 оны хэрэгжилтэд явцын хяналт шинжилгээ хийсэн байна. <b>/100 хувь/</b>	II, IV улирал	ХШҮДАХ
51.Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг холбогдох хууль, журмын дагуу боловсруулах, батлах	Төсвийн урсгал зардлаар	Албан тушаалын тодорхойлолт батлагдсан байх <b>/Хувь/</b>	Газрын даргын 2020 оны 03 дугаар сарын А-136 тоот тушаалаар батлуулсан.	Газрын зохион байгуулалтын бүтэц болон хууль тогтоомжийн өөрчлөлтөд нийцүүлэн албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, зөвшөөрөл авч, батласан байна. <b>/100 хувь/</b>	II-III улирал	ТЗҮХ
52.Газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн төслийг шинэчлэн боловсруулах		Төслийг боловсруулсан байх <b>/Хувь/</b>	Ерөнхий сайдын 2019.11.11-ний өдрийн 153 дугаар захирамж	Газрын зохион байгуулалтын бүтэц болон хууль тогтоомжийн өөрчлөлтөд нийцүүлэн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан байна. <b>/100 хувь/</b>	II-III улирал	
53.Газрын үйл ажиллагаатай холбогдох төлөвлөгөөг боловсруулах, батлах		Төлөвлөгөөний тоо <b>/Тоо/</b>	-	Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт нийцүүлэн байгууллагын стратеги, төлөвлөгөө, 2021 оны	I-II улирал	

				гүйцэтгэлийн төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батласан байна. <b>/ 3 төлөвлөгөө /</b>		
54.Газрын үйл ажиллагаатай хамааралтай тайланг гаргах		Нэгтгэсэн тайлангийн тоо <i>/Удаа/</i>	2020 онд газрын үйл ажиллагаатай холбогдох тайланг тухай бүр гаргаж, эрх бүхий байгууллагад хүргүүлсэн.	Хууль тогтоомжид заасан хугацаанд холбогдох тайланг гаргасан байна. <b>/ 6 удаа /</b>	I-IV улирал	ТЗУХ
55.Байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журмын төслийг батлах	Төсвийн урсгал зардлаар	Дүрэм, журмын тоо <i>/Тоо/</i>	-	Газрын хөдөлмөрийн дотоод журам, Албан хэрэг хөтлөлтийн журмыг шинэчлэсэн батласан байна. <b>/ 2 журам /</b>	I-III улирал	ТЗУХ
56.Газрын хоёр талын болон олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар уулзалт, арга хэмжээ зохион байгуулах		Холбогдох хурал,уулзалтыг тухай бүр зохион байгуулсан байх <i>/Хувь/</i>	-	Холбогдох хурал,уулзалтыг тухай бүр зохион байгуулж ажилласан байна. <b>/ 100 хувь /</b>	I-IV улирал	Холбогдох нэгжүүд
57.Албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, чадавхыг бэхжүүлэх, туршлага солилцох боломжийг бүрдүүлж, гадаад сургалт, хурал, семинарт хамрагдахад дэмжлэг үзүүлэх	Төсвийн урсгал зардлаар	Албан хаагчдад дэмжлэг үзүүлсэн байх <i>/Хувь/</i>	-	Албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, туршлага солилцох гадаад сургалт, хурал, семинарт хамрагдахад тухай бүр дэмжлэг үзүүлж ажилласан байна. <b>/ 100 хувь /</b>	I-IV улирал	ТЗУХ
58.Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Төсвийн урсгал зардлаар	Төсөөлөл гаргасан байх <i>/Хувь/</i>	-	Төрийн захиргааны төв байгууллагын зохион байгуулалтын бүтцийн төсөөлөл гаргасан байна. <b>/100 хувь/</b>	I-III улирал	ХБТХ ТЗУХ

байгуулах бэлтгэл ажлыг хангах <sup>1</sup>						
59.Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиудыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх талаар хуулийн төсөл боловсруулах <sup>2</sup>	Төсвийн урсгал зардлаар	Хуулийн төсөл боловсруулсан байх  /Хувь/	2020 онд 74 хуулийн төсөл боловсруулж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад хүргүүлсэн.	Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн төсөлд нийцүүлэн боловсруулсан байна.  / 100 хувь/	I-III улирал	ХБТХ
60.Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх, дүгнэлт гаргах <sup>3</sup>		Дүгнэлт, санал гаргаж, Улсын Их хурлын тогтоолын төсөл боловсруулсан байх  /Хувь/	-	Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлж, Улсын Их хурлын тогтоолын төсөл боловсруулсан байна.  /100 хувь/	I-II улирал	

-----0000000-----

<sup>1</sup> Монгол Улсын Их хурлын 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн "Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай" 10 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг.

<sup>2</sup> Монгол Улсын Их хурлын 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн "Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай" 45 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг.

<sup>3</sup> Монгол Улсын Их хурлын 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн "Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай" 45 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг.